

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (JICA/DPUB)

Мэдээллийн эмхэтгэл No.32 (2020.01)



DET Сургагч багш бэлтгэх 3 дахь удаагийн сургалтын төгсөлт

Монголд анх удаа “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт”-ын Трэйнер төрөн гарлаа! (2019.12.25)

12-р сард зохион байгуулагдсан Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын лекц болон дасгал ажлуудыг Болороо, Гэрэлцэцэг, Энхням нар удирдан явууллаа. Тэд Трэйнер бэлтгэх сургалтад 10-р сараас эхэлж хамрагдсан бөгөөд энэ удаагийн сургалтын зохион байгуулалтыг хариуцсан юм. “Сургагч багш бэлтгэх явцад багийн ажиллагаа, мөн бэлтгэл ажил ямар чухал үүрэгтэй талаар ойлгосон бөгөөд юу юунаас илүүтэйгээр тэвчээртэй байхад суралцлаа!” Энэ 3 сарын хугацаанд хичээл заахын тулд өглөөнөөс орой хүртэл суралцсан... хэмээн ярих Трэйнерүүд бага зэрэг ядарсан шинжтэй байсан ч их ажлын ард гарч үр дүнг нь үзсэндээ сэтгэл хангалуун байв.

Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалтын Сургагч багш бэлтгэх 3 дахь удаагийн сургалт амжилттай болж өндөрлөлөө (2019.12.24)

12-р сард Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын Сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулагдлаа. Монгол улсад 3 дахь удаагаа явагдсан энэ удаагийн сургалтад Дорнод, Баянхонгор гээд хөдөө орон нутгийн иргэд анх удаагаа оролцов. 11 өдрийн урт хугацааны сургалтыг 14 хүн амжилттай төгссөн. “Хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголттой хэмээн бодож байсан ч өдөр бүрийн хичээлээс суралцах зүйл олон байлаа. Хамгийн их сурч авсан зүйл бол хүнд ойлгуулах аргачлал байсан” хэмээн сургалтын бодит үр дүнгийн талаар оролцогчид ярьж байв. Төслийн хүрээнд 3 жилийн хугацаанд 46 сургагч багшийг бэлтгэн гаргаад байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө нийгмийн саадыг арилгахын тулд баг бүрдүүлэн үйл ажиллагаа явуулах болно!



Зүүн гар талаас Энхням, Болороо, Гэрэлцэцэг



Тайлангийн хурал ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газарт боллоо

авсныхаа дараа Трэйнерүүд “баярлахаасаа илүүтэйгээр өндөр хариуцлага үүрэх болсноо мэдэрч байна” хэмээн ярьж байв. Хөгжлийн бэрхшээлийн салбарын манлайлагч байж, шинэ алхам хийсэн тэдэндээ баяр хүргэе.



Сургалтын явцаас

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2 дахь удаагийн семинар

2019 оны 5-р сард анх удаагаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн семинарыг зохион байгуулсан бөгөөд түүнээс хойш хагас жилийн хугацаа өнгөрчээ. 5-р сард болсон семинарын үеэр хөгжлийн бэрхшээлийн Нийгмийн загвар болон НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн үзэл санааг үндэс болгон, 14 яамны Дэд зөвлөлүүдийн үйл ажиллагааны нөхцөл байдалтай танилцаж, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцсэн. Үүнээс хойш дэд зөвлөлүүд ямар үйл ажиллагаа явуулж байгаатай танилцах, мөн цаашдын үйл ажиллагааг нь дэмжих зорилгоор 11-р сарын 29-нд семинар хийлээ. Семинар болохоос долоо хоногийн өмнө 4 Дэд зөвлөлийн үйл ажиллагаатай танилцсан үр дүнгээ тайлагнахаас гадна бусад улс орны төр захиргааны байгууллагын салбар дундын үйл ажиллагаа, санал санаачилгыг танилцуулан, Монгол улсад хэрэгжилтийг хангах тогтолцоог хэрхэн бүрдүүлэх тал дээр зөвлөмж өглөө. Төгсгөлд нь дээрх агуулгуудыг үндэс болгон, Дэд зөвлөлүүд ширээ ширээгээрээ ирэх оны үйл ажиллагаа руу чиглэсэн хэлэлцүүлэг өрнүүлэв. Хэлэлцүүлгийн гол сэдэв нь тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд яамдуудын салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх, төрийн байгууллагууд ХБИ-ийг ажлын байраар хангах гэх мэт нэн тэргүүнд тавигдах асуудлууд руу чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, ХБИ-ийн ТББ-уудын оролцоотойгоор тогтмол хугацаанд хурал явуулах, хяналт тавьж ажиллах зэрэг агуулгууд байв. Дэд зөвлөлүүд ирэх оны төлөвлөгөөгөө боловсруулан батлах хугацаа дөхсөнөөс гадна “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагаа мэдээллийн лавлах” номны 3 дахь удаагийн хэвлэлд Дэд зөвлөлүүдийн жилийн тайланг нийтлэхээр төлөвлөж буй учраас цаашдын холбогдох үйл ажиллагаанууд ч анхаарал татаж байна.



Хэлэлцүүлгийн үеэр

Санхүүжилт олгох үйл ажиллагааны дурсамжууд



Ахлах зөвлөх Чива Хисао

Япон сангийн тусламж үзүүлсэн байгууллагуудаас хамгийн сэтгэлд хүрсэн нь Камбожийн харааны бэрхшээлтэй иргэдийн байгууллага. Англи нэр нь “Association of the Blind in Cambodia” учраас товчлоод ABC гэж нэрлэдэг байв. Тус байгууллагын тэргүүн Боун Мао (Mr. Boun Mao) нь мотоциклийн дээрэмд өртөж, хүхрийн хүчил цацуулснаас болж хараагаа алдсан. Тэрээр ямагт аливаа зүйлд эерэгээр ханддаг, эрдэм мэдлэгт суралцахыг эрхэмлэж явдаг хүн. Надад харааны бэрхшээлтэй иргэдийн манлайлагч нар бүгд мэдээлэл, мэдлэг олж авахад сайн утгаараа шуналтай ханддаг юм шиг санагддаг. Тиймээс түүнтэй ярилцах үед би ч гэсэн маш олон мэдээлэл өгөх шаардлага гардаг учраас сандрах мэдрэмж төрдөг байлаа. Түүнээс гадна харааны бэрхшээлтэй иргэдийн дээд боловсролыг дэмжих ажил болон хараагүйчүүдийн массажны үйл ажиллагаа сэтгэлд үлджээ. Монголд ч гэсэн харааны бэрхшээлтэй иргэд массажны үйлчилгээ үзүүлж байсан тул анх удаа Монголд тэр шугамаар ирж байв. Тухайн үед Бэст массажны төв 3 салбартай л байсан бол өдгөө 30 гаруй салбартай болж үйл ажиллагаа нь амжилттай явагдаж байна.

DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: [https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Төслийн фэйсбүүк хуудаст “LIKE” дарж нэгдээрэй.

Цахим хуудас: [https:// www.jica.go.jp/project/ mongolia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html)

И-мэйл: dpub.jica@gmail.com